



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 11/77

Бат-Өлзий сум


Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий суманд өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан малчдад хөнгөлөлттэй үнээр малын нэмэлт тэжээл (долооц) худалдан авах зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Эрсдлээс хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН